

**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ
ТҮРЭЭСЛЭХ ГЭРЭЭ
Дугаар №**

2022 оны 06-р сарын 15 ны өдөр

Улаанбаатар хот

1. Нийтлэг үндэслэл

1.1. Нэг талаас Амгалан дулааны станц ТӨХК /цаашид захиалагч гэх/, нөгөө талаас **Роял эм экс эм ХХК** /цаашид гүйцэтгэгч тал/ нар нь харилцан тохиролцон тоног төхөөрөмж түрээслэн авах гэрээг доорхи нөхцөлөөр байгуулав.

1.2. Тоног төхөөрөмжөөр үйлчлэхтэй холбогдсон харилцааг энэхүү гэрээгээр зохицуулна.

1.3. Хоёр тал хамтран ажиллахдаа Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгон гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, нэгнийхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг баримтлан ажиллана.

2. Гэрээний хугацаа, нөхцөл, төлбөр тооцоо

2.1. Гэрээний хугацаа.

Гэрээнд талууд гарын үсэг зурж баталгаажсан өдрөөс эхлэн тайз болон тоног төхөөрөмжөөр үйлчилж дуусах хүртэл хүчинтэй.

2.2. Төлбөр тооцоо.

- Гэрээний нийт үнийн дүн / **11,170,000** / төгрөг /Арван нэгэн сая нэг зуун далан мянган төгрөг/ /НӨАТ-гүй дүн/
- Арга хэмжээ эхлэх огноо, байршил:
2022 оны 6 дугаар сарын 16 ны 10:00 цагаас Амгалан дулааны станц ТӨХК-д

3. Захиалагчийн эрх, үүрэг

3.1. Гэрээнд гарын үсэг зурсанаар арга хэмжээнд ашиглах тоног төхөөрөмж / Зориулалтын Тайз, Карказ, Лэд дэлгэц, Хөгжим/ -ийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.

3.2. Тайзанд хамгийн ойр болон боломжит газрыг нөхцөлд стандартад нийцсэн 380 вольтийн цахилгаан хүчдлээр хангах үүргийг хүлээнэ.

3.3. Захиалагч тал нь түрээслэн авч байгаа тоног төхөөрөмжийг арга хэмжээ зохион байгуулагдаж байгаа газар харуул хамгаалалтыг хариуцан ажиллана.

4. Гүйцэтгэгч талын эрх үүрэг

- 4.1. Гүйцэтгэгч тал нь захилагчтай хийсэн гэрээний дагуу арга хэмжээ болох тухайн газарт тоног төхөөрөмжийг угсарч бэлэн байлгах үүрэгтэй.
- 4.2. Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлбөрөө бүрэн барагдуулаагүй тохиолдолд тоног төхөөрөмжийг суурилуулахгүй байх эрхтэй.
- 4.3. Гүйцэтгэгч тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ захиалагчын зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.
- 4.4. Захиалагч талын эрсдэл нь гүйцэтгэгч талын төлбөр авах эрхэд нөлөөлөхгүй.
- 4.5. Тоног төхөөрөмжийг зөөвөрлөх, суурилуулах явцад гэнэтийн осол, хөдөлмөр хамгаалалын журам зөрчигдсөн, эвдрэл гэмтэл гүйцэтгэгч тал хариуцна.

5. Төлбөр тооцоо

- 5.1 Түрээсийн үйлчилгээний төлбөрийг дараах графикийн дагуу хийнэ.

№	Төлбөр хийх хугацаа	Төлбөрийн дүн	Данс
1.	Гэрээ байгуулсан өдөр буюу 2022 оны 6-р сарын 15-ны өдөр	9,670,000	ХХБ 453207493 Роял Эм Экс Эм ХХК
2.	Арга хэмжээ дуусах өдөр буюу 2022 оны 6-р сарын 16-ны өдөр	1,500,000	ХХБ 453207493 Роял Эм Экс Эм ХХК
3.	Нийт дүн	11,170,000	НӨАТ-гүй дүн

6. Бусад

- 6.1. Гэрээг 2 хувь үйлдэх бөгөөд адил хүчинтэй байна.
- 6.2. Гэрээнд гарын үсэг зурж тэмдэг дарж баталсанаар гэрээ хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний заалтууд бүрэн биелэх хүртэл үргэлжилнэ.
- 6.3. Гэрээнд оруулах нэмэлт өөрчлөлтийг талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр зөвхөн бичгээр оруулж гарын үсэг тэмдэгээр баталгаажуулна.
- 6.4. Талуудын хүсэл зоригоос үл хамаарах давагдашгүй хүчин зүйл /ЗГ-ын шийдвэр, Хотын цахилгаан шугам сүлжээ, Байгалийн үзэгдэл г.м./-ээс хамааран үйлчилгээнд саатал гарвал гүйцэтгэгч тал хариуцахгүй ба дээрхи нөхцөл байдлаас гарах хохиролыг захиалагч тал 100 хувь хариуцана.

6.5. Маргаантай асуудал үүссэн тохиолдолд асуудлыг гэрээний дагуу 2 тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцоонд эс хүрвэл МУ-ын хуулийн дагуу шийдвэрлүүлнэ.

3.6. Гэрээний нууцлалыг талууд чанд сахиж гуравдагч этгээдэд дамжуулахыг хориглоно.

Гэрээг байгуулсан:

Гүйцэтгэгч талыг төлөөлж:

Албан тушаал: Менежер

Нэр: Г. Мөнхбаяр

Гар утас: 88064333

Ажлын утас:

Факс:

Хаяг: Баянзүрх дүүрэг, 14-р хороо,
36 байр, 100

Гарын үсэг: *Г. Мөнхбаяр*

Тамга:



Захиалагч талыг төлөөлж:

Албан тушаал: Гүйцэтгэх захирал

Нэр: Ш.Баянмөнх

Гар утас:

Ажлын утас: 77111251

Факс:

Хаяг: Баянзүрх дүүрэг 8-р хороо УС-15-1-1

Гарын үсэг: *Ш.Баянмөнх*

Тамга:

